БАТЛАВ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
С.ДАВААСҮРЭН

2025 оны 07 дугаар сарын 02

ТӨРИЙН АРХИВ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР
№ ЗД-15

2025 оны 06 дугаар сарын 27 Багануур дүүрэг

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	-"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.4.18.Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна. - Багануур дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит VII хуралдааны 10 дугаар тогтоолын тавдугаар хавсралт; - Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/138 дугар захирамжаар 4362893 нэгж талбарын дугаартай 800 м2 газар эзэмших шийдвэр;
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Багануур дүүргийн 3 дугаар хороо Наран хороолол Нийслэлийн 142 дугаар цэцэрлэгийн урд зүгт Төрийн архивын барилга барих зориулалтаар эзэмшүүлсэн 4362893 нэгж талбарын дугаартай 800 м2 газар;
3	Одоогийн байдал	- Архивын хэлтэс нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны нэг давхарт тус байрны цайны газрын үйлчилгээний заалны зориулалт бүхий 104 мкв өрөөнд Засаг даргын Тамгын газрын буюу байгууллагын архивын хамт хадгалж байгаа тул 2 тусдаа чиг үүрэг бүхий 2 байгууллагын баримтуудыг тусгаарлах шаардлагатай. - Мөн архивын өрөө нь хадгалалтын чийгийн хэмжээг гадна орчноос хамаарахгүйгээр агааржуулалтын системээр зохицуулж хянах ёстой байтал зориулалтын болон зохиомол агаар сэлгэлт хийх нөхцөлөөр хангагдаагүй байна. - 2025 оны эхний хагас жилийн байдлаар 49 хөмрөгийн 8128 баримт хадгалж байгаа бөгөөд 2026 оноос багтаамж дүүрч холбогдох журмын дагуу баримтыг хадгалж хамгаалахад хүндрэл үүсэж байна. - Улсын бүртгэлийн хэлтэс нь ЗДТГ-ын 1-р давхрын баруун жигүүрт 154 м2 талбайд төрийн үйлчилгээг үзүүлдэг. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн 30 м2 талбайд 43100 хувийн хэргийг хадгалж байгаа бөгөөд зай талбай хүрэлцээгүй болсон.
4	Зориулалт, хүчин чадал	-Төрийн архивын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн 2 байгууллагын 35 албан хаагчтай. **Архивын хэлтэс:** -Архивын удирдлагын өрөө (туслахын өрөө) -Сан хөмрөгчийн өрөө, -Ажилтнуудын өрөө, (4 өрөө) -Баримт хүлээн авах өрөө,

		-Хадгаламжийн сан (цаасан суурьт баримтын-3, тусгай төрлийн-1), -Эрдэм шинжилгээ лавлагааны сан буюу тоо бүртгэлтийн өрөө, -Кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн баримтын чанарыг шалгах өрөө, -Боловсруулах, цахимжуулах тусгай зориулалтын өрөө, -Баримт сэргээн засварлах өрөө, -Лаборатори, Баримт ариутгах өрөө, -Арга зүйн танхим, -Серверийн өрөө, -Уншлагын танхим, -Уншлагын танхимын (уншлагын танхимд олгогдох баримтыг түр хадгалах өрөө) -Иргэдэд үйлчлэх танхим, -Үзэсгэлэнгийн танхим, -Хурлын танхим, - Агуулах, -Аж ахуйн өрөө, -Хувцасны өлгүүр, цүнх, гар тээш хадгалах өрөө, -Шалган нэвтрүүлэх хэсэг, -Үйлчилгээний ажилтны өрөө, -Ариун цэврийн өрөөнүүдээс бүрдэнэ. Улсын бүртгэлийн хэлтэс: -Ресепшн (мэдээлэл лавлагаа – Иргэдэд чиглүүлэгч, анхан шатны мэдээлэл -Үйлчилгээний цонхнууд (6-10) - Бүх төрлийн бүртгэл (иргэний эд хөрөнгийн хуулийн этгээд, нотариатын үйлчилгээ) -Цахим бүртгэлийн булан – Иргэн өөрөө лавлагаа авах хэсэг -Хүлээлгийн танхим – 30-50 суудалтай, зар мэдээний дэлгэцтэй байх -Хэлтсийн дарга, бичиг хэрэг -Иргэний бүртгэлийн мэргэжилтнүүд 2-3 өрөө -Эд хөрөнгийн бүртгэл (үл хөдлөх, өмч бүртгүүлэх) -Хуулийн этгээдийн бүртгэл (ХХК, ТББ, нөхөрлөл гэх мэт) -Мэдээлэл технологийн өрөө (Сервер) -Архивын өрөө (түр хадгалалт) -Гэрлэлт баталгаажуулах ёслолын танхим (30-50 хүний суудалтай, ёслолын тавцантай) -Архивын стандарт нийцсэн тусдаа блок, хадгалалтын хэсгүүд (чийгийн өндөр хамгаалалттай) -Хурал, сургалтын танхим 20-30 хүний байгтаамжтай -Иргэдтэй уулзах танхим (нууцлалтай зөвлөгөө өгөх орчин) -Ариун цэврийн өрөөнүүд (эрэгтэй, эмэгтэй) -Амралтын өрөө (ажилчдын) -Харуул, камерын өрөө (аюулгүй байдал хангах өрөө) -Үйлчлэгч цэвэрлэгээний зориулалтын агуулах гэсэн өрөөнүүдээс бүрдэнэ.
5	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага	-Тухайн барилга байгууламжийг эдэлбэр хэмжээнд холбогдох норм, дүрмийн дагуу төлөвлөх, боловсруулах. Үүнд: -Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30.01.04/-ийн дагуу тооцож, төлөвлөх; -БНбД 23-04-07-гийн дагуу нарны эзэрлэлтийг тооцох;

		- Авто зогсоолыг эдэлбэр газарт багтаан БНбД 21-05-10-ын дагуу төлөвлөх; - Барилга, байгууламжийн авто зогсоол байрлах хэсэг нь "Дуу чимээ тусгаарлалт" /БНбД23-05-10/-ийн дагуу эрүүл ахуйн хэм хэмжээнд тохирсон дуу чимээний түвшинг хангасан байх; - Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлага, нөхцөлийг БНбД 35-01-22-ын шаардлагын дагуу тооцох; - Бусад шаардлагатай барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдлөг болгох.
6	Архитектур төлөвлөлтийн шаардлага	- Загвар зураг төслийг Хот байгуулалт, хотын стандартын газраас Архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргуулан батлуулж, холболтын ажлын зургийг гүйцэтгэх; Барилгын давхрын тоо: - Холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөлтөөр тооцох (Зоорийн давхрын хамт 4 давхар байх) Барилгажих талбай: -Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д заасны дагуу төлөвлөх; -Баганаар дүүргийн хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөөтэй талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтыг уялдуулах; Барилгын үндсэн бүтээц: -Цутгамал төмөр бетон каркас -Барилгын ажлын зураг төслийг холбогдох норм, дүрэм болон бусад баримт бичгийн шаардлагыг хангуулан боловсруулах. Үүнд: -Өрөө тасалгаанд тавигдах ерөнхий шаардлагыг , Архивын зориулалтын барилга MNS 6929-2021 стандарт, Олон нийт иргэний бари лга БНбД 31-03-03/11, Захиргааны зориулалттай олон нийтийн барилга БНбД 31-04-12 барилгын норм дүрмийн дагуу тооцох; -Өрөө тасалгааг нарны хэт халалтаас хамгаалах ба өрөөнд тусах нарны тусгалын тооцооллыг БНбД 23-04-07-гийн дагуу төлөвлөх; -Барилгын зохиомол гэрэлтүүлгийг БНбД 23-02-08-ын шаардлагын дагуу төлөвлөх. Галын аюулаас хамгаалах арга хэмжээ: -ЗГ-ын 2023 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"; -БНбД 21-02-02, БНбД 21-04-05*/18-ын шаардлагын дагуу төлөвлөх; -Бусад шаардлагатай барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдлөг болгох.
7	Ажлын зураг төсөлд тавигдах төлөвлөлтийн шаардлага	-Ажлын зураг төсөл боловсруулахдаа ашиглагч, захиалагч байгууллагуудтай зөвшилцөж гүйцэтгэх; -Дүүргийн барилгажилт, гадна тохижилт, зам талбай, суурьшлын бүсийн зай талбайг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, норм дүрмийн дагуу хүчин чадлыг нарийвчлан тогтоох; -Зураг төслийг боловсруулах явцад дүүргийн цаг уур газар нутаг хөрсний бүтэц зэргийг сайтар судлан тарих мод, ургамал хийх ажлын онцлогийг тусгаж өгөх;

		-Гадна цахилгаан, дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийн зураг төслийг БЗӨБЦТС ТӨХК-ийн 2025 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; -Халаалт, агаар сэлгэлтийг Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2025 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; -Ус хангамж, ариутгах татуургын системийг Багануур-Ус ААТҮГ-ын 2025 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; -Холбоо дохиоллын зураг төслийг боловсруулахад Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Багануур дүүргийн газрын 2025 оны ..... сарын ..... -ны өдрийн №..... дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн барилгын талбайн ойр орчмын инженерийн шугам сүлжээний нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; -Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох; -Шаардлагатай тохиолдолд өөрийн эх үүсвэрээр (цахилгаан) хангах зураг төсөв боловсруулан холбогдох байгууллагуудаар зөвшилцөн батлуулах шаардлагатай. -Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан төлөвлөх; -Гадна шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, зөвшилцөх; Дүүргийн цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж ажлыг төлөвлөн шугамын тооцоог хийх;
8	Инженер шугам, сүлжээнд тавигдах шаардлага	-Хангагч байгууллагаас олгогдсон инженерийн хангамжийн техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох, норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөх (дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, холбоо мэдээлэл)
9	Инженерийн бэлтгэл арга хэмжээ	-Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баримтлан үерийн хамгаалалт, далан, суваг шуудуу, ус зайлуулах шугам сүлжээг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх.
10	Барилгын улаан шугамын зай	-Магадлалаар баталгаажсан ажлын зураг төслийн дагуу барилгын тэг тэнхлэгийг тавиулж, барилгын ажлыг эхлүүлэх
11	Ажлын зураг төслийн бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> -Инженер геологийн судалгааны дүгнэлт; -Байр зүйн дэвсгэр зураг (М1:500 – М1:1000); -Онцгой байдлын дүгнэлт -Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүгнэлт -Магадлалын дүгнэлтийн нэгтгэл /хавсралт дүгнэлтийн хамт/ -Загвар зураг (М1:100 – М1:150); Ажлын зураг /М1:100 – М1:150/: -Ерөнхий төлөвлөгөө М1:500; -Барилга архитектур М1:100 – М1:150; -Технологийн зураг М1:100 – М1:150; -Барилга бүтээц М1:100 – М1:150.

		Барилга доторх шугам сүлжээ (М1:100 – М1:150): -Дотор халаалт, агаар сэлгэлт; -Цэвэр, бохир ус; -Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг; -Холбоо дохиолол; -Автоматик, удирдлагын зураг төсөл; Гадна инженерийн шугам сүлжээ (М1:100 – М1:500): -Дулаан хангамж; -Ус хангамж, ариутгах татуурга -Цахилгаан хангамж; -Холбоо дохиолол; -Төсөв (магадлал хийсэн ажлын зураг төслийн дагуу төсвийн программаар гүйцэтгэх); -Ажлын зургийн магадлалын дүгнэлтүүд, магадлалын дүгнэлтийн нэгтгэл; -Бусад холбогдох баримт бичиг (Архитектур төлөвлөлтийн даалгавар, Зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцлүүд, холбогдох байгууллагын дүгнэлтүүд. Ажил гүйцэтгэх аргачлал: -Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, загвар зураг болон магадлал хийлгэсэн ажлын зураг, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь 1 хувь, хуулбар 2 хувь хэвлэмлээр, файл (autocad, pdf) хэлбэрээр CD-д бичиж 1 хувь тус тус захиалагчид хүлээлгэн өгнө.
12	Онцгой нөхцөл	-Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа холбогдох барилгын норм, дүрмийн дагуу гадна, дотор орчны зохион байгуулалтыг хийж төлөвлөх; -Зураг төслийг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, тушаал, заавар, БНбД, стандартын дагуу боловсруулна. -Зураг төслийг газар дээр нь ирж орчны нөхцөл байдал болон инженерийн шугам сүлжээний одоогийн байдал хэтийн төлөвлөлттэй уялдуулан, боловсруулах; -Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3-т заасны дагуу хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байх; -Барилга, байгууламжийн норм нормативын баримт бичгийн шаардлагад заасны дагуу эдэлбэр газар, барилга байгууламжид нэвтэрэх орцыг, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд, түүний дотор тэргэнцэртэй хүнд орж гарахад хялбар байдлаар тоноглох болон байгууламжийн талаарх мэдээллийн тэмдэг, тэмдэглэгээг давхар болон өрөө тасалгаа бүрт байрлуулах. Тухайлбал сургуулийн барилгын ойр орчимд явган зорчигч, авто зогсоол, дугуйн зогсоол, анхааруулах тэмдэг, хурд сааруулагч зэргийг төлөвлөхөд MNS 6444:2014-ийн шаардлагыг хангах; -Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй байх гадаад, дотоод орчинг БНбД 35-01-22-ын дагуу төлөвлөх; -Барилгад хүний зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг урьдчилан хамгаалах зориулалттай мэдээлэл системийн хэрэгсэл бүхий заагчийг (харагдахуйц тэмдэг, тэмдэглэгээ, дуут дохиолол, мэдээллийг дүрслэн үзүүлэх хэрэгслүүд) зураг төсөлд тусгах;

		-Барилгад хэрэглэх гадна, дотор заслын материал эрүүл ахуйн чанар, стандартын шаардлага хангасан байх; -Аюулгүй байдлыг хангах, барилгын орчинг камержуулах; -Дэвшилтэт техник, технологи, цахилгаан, дулаан, уур, усны эх үүсвэрийг үр ашигтай төлөвлөх (эрчим хүчний хэмнэлттэй); -Гүйцэтгэгч нь захиалагч, ашиглагчтай ажлын тоо хэмжээний талаар зөвшилцөж боловсруулах; -Барилгын ажилд ашиглагдах материал, тоног төхөөрөмжийн үнийг зах зээлийн судалгаа хийж төсөвт тооцох.
13	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Газрын тухай хууль; - Барилгын тухай хууль; /шинэчилсэн найруулга/ - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 24.1.1, 24.1.2 - Эрчим хүчний тухай хууль; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Архивын тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд <u>Төсөл, хөтөлбөрүүд:</u> - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; - "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" - Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор батлсан "Багануурын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" <u>Норм, норматив</u><u>ууд:</u> - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа БД 11-102-07 - Барилга, байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох БНбД 50-01-16 - Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил БНбД 50-02-17 - Цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНбД 52-02-05 - Цутгамал төмөр бетон бүтээцийн зураг төсөл зохиох заавар БНбД 52-102-04 - Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-06 - Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-01-14 - Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж /БНбДЗ.05.04.90/ - Усан хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам БД 40-102-06 - Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга БНбД 40-05-16 - Дотор сантехникийн систем БНбД 40-06-16

		- Ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам БД 40-102-06 - Цахилгаан байгууламжийн дүрэм (БД 43-101-03) - Автоматжуулалтын систем (БНбД 3.05.07-90) - Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 "Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ" БД 43-101-03*12 - Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төсөллөх ба угсрах БД 43-102-07 - Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм (БД 30-102-11) - Барилгын гадна тохижилтод тавигдах шаардлага, бага насны хүүхдийн онцлог, орчин үеийн шийдлийг тусгаж төлөвлөх - Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм (БД 30-102-11) - Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21-01-02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21-02-02 - Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм БНбД 22-04-16 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох БД 31-112-11 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм, заавар <u>Холбогдох стандартууд:</u> -Архивын зориулалттай барилга MNS6929-2021 - Барилгын бүтээцийн материал /өргийн материал, бетон,арматур/ түүнд тавигдах ерөнхий шаардлага UCS 1501C:2020 - Уур, ус тусгаарлагч материал UCS 1503C:2020 - Хаалга, цонх UCS 1504C:2020 - Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1506C:2020 - Халаалт агаар сэлгэлтийн материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1507C : 2020 - Сантехникийн материалд тавигдах шаардлага UCS 1508C : 2020 - Барилга, замын ажил гүйцэтгэх иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0001-01:2019 - Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009, MNS 6056:2009 - Цайрдсан ган хоолой ГОСТ 3262-75 - Хуванцар хоолой MNS ISO 15874-2 : 2007 - Эмульс MNS ASTM 977:2004 - Гипс MNS 5925:2008 - Ган хоолой MNS ISO 6759:2004 - Лотки MNS 3875 : 86 MNS 0887 : 83 - Дулаалгын материал MNS EN 13163 : 2011 - Тоосго MNS 5610 : 2014 - Шохой MNS 0554 : 1987 - Дүүргэгч материал MNS 2803 : 2004

		- Бусад холбогдох стандартууд - Цемент MNS 3091 : 2008 - Арматур MNS 2797 : 2001 - Арматур MNS ISO 6934-2:2003, MNS JIS G 3112:2002, ГОСТ 6727-80 - Хайрга MNS AASHTO 43:2002 - Бэхэлгээний ган эд анги MNS 4237:94 Холбогдох дүрэм, журмууд: - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм (Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол) - Барилгын ажлын захиалагчийн дүрэм (Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, 2018 оны 316 дугаар тогтоол нэмэлт, өөрчлөлт) - Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм (Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал) - Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам (Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаал) Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам (Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоол)
14	Зургийн үе шат, хугацаа	1 үе шаттай; - Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
15	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх 88,490,000 (наян найман сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөг;
16	Захиалагч байгууллага	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, Архивын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс;
17	Зураг төсөл боловсруулах байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих нөхцөл, шаардлага" ▪ ЗТ-4.1 Дунд болон өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл, орчны тохижилт; ▪ ЗТ-6.1 Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл; ▪ ЗТ-6.2 Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл; ▪ ЗТ-6.3 Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35 кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл;

		Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл автоматикийн зураг төсөл; ▪ ЗТ-6.4 Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл; ▪ ЗТ-9.1 Багаас өндөр төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа (инженер-геологийн нөхцөл харгалзахгүй) ▪ ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв; тус тус тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллага байна.
18	Зөвшөөрөлцөх байгууллага	1. Батлах байгууллага: 1.1. Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар; 2. Зөвшөөрөлцөх байгууллага: 2.1. Багануур дүүргийн Газар, зохион байгуулалтын алба; 2.2. Багануур-Ус ААТҮГ; 2.3. Багануурын дулааны станц ТӨХК; 2.4. БЗӨБЦТС ТӨХК; 2.5. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Багануур дүүргийн газар; 3. Зөвшилцөх байгууллага 3.1. Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар; 3.2. Архивын хэлтэс; 3.3. Улсын бүртгэлийн хэлтэс;

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Б.МӨНХЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН АРХИВЫН ЗААВАРЛАГЧ, АРГА ЗҮЙЧ — Б.ЭРДЭНЭТУЯА

ЗӨВШИЛЦСӨН:
АРХИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Ц.ТҮВШИНЖАРГАЛ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Н.ЖАВХЛАНБААТАР